



Швейцарийн хөгжлийн агентлагийн
Цөлжилтийг сааруулах төсөл
МОНГОЛД



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

Энэхүү ном нь Швейцарийн хөгжлийн агентлагийн Цөлжилтийг сааруулах төсөл (ЦСТ)-өөс 2007-2012 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гарсан онцлох үр дүн бүхий зурагт цомог юм.

Энэ цомгийг төслийн тайлан гэж ойлгохоос илүү төслийн үйл ажиллагааны зурган баримтууд хэмээн хүлээн авна уу.

Талархал

Өнгөрсөн хугацаанд бидний үйл ажиллагааг дэмжиж, идэвхитэй хамтран ажиллаж ирсэн төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн болон хувь хүмүүс, малчид, тариаланчид, хүүхэд залуус, хэвлэлийнхэн болон сэтгүүлчид, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдэд чин сэтгэлийн талархал дэвшүүлж, ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Цөлжилтийг сааруулах төсөл (ЦСТ)-ийн хамт олон

Эмхэтгэн боловсруулсан:
А.Хандармаа - ЦСТ-ийн мэргэжилтэн
ЦСТ-ийн мэргэжилтнүүд

Зураач:
С.Цогтбаяр /СГЗ/

Гэрэл зургийг:
Швейцарийн хөгжлийн агентлаг
Цөлжилтийг сааруулах төсөл
Ханспитер Линигер
Гамма агентлаг

Хянан тохиолдуулсан:
Г.Даваадорж - ЦСТ-ийн захирал
С.Энхболд - ЦСТ-ийн менежер

Хэвлэлийн эхийг гэрэл зургийн “Гамма фото” агентлагт бэлтгэж, хэвлэв.

Хамтран ажилласан:
Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Боловсрол, шинжлэх ухааны яам
Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо

Улаанбаатар 2012



Өмнөх үг

Сүүлийн 100 гаруй жилийн хугацаанд дэлхийн агаар мандлын жилийн дундаж температур 0.7°C –аар дулаарсан байхад манай улсын хувьд 1940-2008 онд дунджаар 2.14°C-аар дулаарсан нь дэлхийн дунджаас гурав дахин эрчимтэй байна.

Манай улсын гадаргын усны 2011 оны тооллогын дүнгээр 180 гол горхи, 481 нуур цөөрөм хатаж ширгэсэн байна. Энэ бүгд нь улс орны нийгэм, эдийн засгийн бүх салбарт нөлөөлж, ялангуяа бэлчээрийн мал аж ахуй, усалгаагүй үр тарианы үйлдвэрлэл зонхилсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн амьжиргаанд шууд нөлөөлж байна.

Зун нь гандуу байж, өвөл нь ахиу цас ороход олон аймаг, сумыг хамарсан зуд болж, 4-11 сая толгой мал хорогдож, хэдэн мянган малчин өрх амьжиргааны эх үүсвэргүй болсоноос хот суурин газрыг бараадан нүүж, ирсэн газрынхаа нийгмийн үйлчилгээг хүндрүүлж байна.

Монгол орны нийт газар нутгийн 90 гаруй хувь нь цөлжилтөнд өртөмтгийн хуурай, хагас хуурай бүсэд хамрагддаг ба 72.3 хувь нь цөлжилтөнд ямар нэгэн хэмжээгээр өртсөн гэж тодорхойлсон байдаг.

Энэ бүх нөхцөл байдлыг харгалзан Монгол улсын Засгийн газраас цөлжилттэй тэмцэх хүчин чармайлтыг дэмжих хүсэлтийг Швейцарийн хөгжлийн агентлагт тавьсаны үр дүнд 2007 оноос “Цөлжилтийг сааруулах” төслийг хэрэгжүүлэхэд техник, санхүүгийн дэмжлэг үзүүлэн хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд үндэсний хэмжээний чадавхи бэхжүүлэх, байгалийн нөөцийг үр ашигтай тогтвортой ашиглах, хүүхэд, залууст байгаль орчны боловсрол олгох, иргэдэд цөлжилтийн тухай үнэн бодит мэдээлэл хүргэх, цөлжилтийг сааруулах мэдлэгийн менежментийг нэвтрүүлэх чиглэлээр Монгол улсын болон монголд үйл ажиллагаа явуулж буй хандивлагч орнуудын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж төсөлд хамрагдсан бүс нутагтаа хүний нүдэнд тусч, гарт мэдрэгдэхүйц бодит үр дүн гаргахын тулд чармайн ажиллаа.

Энэхүү номонд бид дээрхи ажлын хүрээнд гарсан бодит үр дүнгүүдийг зургаар илэрхийллээ. Төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг зураг, дүрсээр илэрхийлж таниулах нь уншигчдад илүү ойлгомжтой, ээлтэй байна хэмээн үзэж байгаагаас гадна бидний үйл ажиллагаа, үр дүнг бусад тохиолдолд загвар, гарын авлага болгон ашиглах, иш татах боломжтой болгохыг хичээсэн юм.

Та бүхэн бидний энэхүү номтой танилцаж, зарим үйл ажиллагаа, үр дүнг лавшруулан тодруулах шаардлага гарвал www.greenmongolia.mn цахим хуудсанд хандах, эсвэл ulaanbaatar@greenmongolia.mn цахим шуудангийн хаягаар холбогдоно уу.

Бидний үйл ажиллагаа, гаргасан амжилт, үр дүнг уншиж танилцахад цаг заваа гаргасан уншигч танд талархалаа илэрхийлье.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Доктор профессор Г. Даваадорж,
Төслийн захирал,
МУ-ын Гавъяат агрономич

Швейцарийн хөгжлийн агентлагийн Цөлжилтийг сааруулах төсөл

ЗОРИЛГО:

Монгол Улсын цөлжилттэй үр бүтээлтэй, идэвхтэй тэмцэх чадавхи дээшлүүлэх, тус улсын гандуу хуурай нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үндэсний болон олон улсын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 1:

Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны чадавхыг бэхжүүлэх

Цөлжилтийн мониторинг, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгож түүнд оролцогч байгууллагуудын чадавхийг сайжруулах

Бүрэлдэхүүн хэсэг 2:

Ховд аймгийн Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрөө боловсруулж хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

Ховд аймгийн тариаланчидад усны менежментээ сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 3:

Байгаль орчны мэдээлэл сурталчилгааг сайжруулахад төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах,

“Эко-сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 4:

Мэдлэгийн менежмент

Цөлжилтийг сааруулах дотоод, гадаа -дын тохиромж-той арга технологийн сан буй болгох, турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд туслах

Бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх



2010 онд Монгол Улсын Засгийн газраас батлагдсан Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн шинэчлсэн хувилбарыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөрийг мөн онд боловсруулж Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар (АИТХ) батлан, жил бүр шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байна.




Засгийн газрын хуралдаан говьд

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2015 он хүртлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсанаар Ховд аймагт цөлжилттэй тэмцэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага, санхүүгийн эх үүсвэр тодорхой болж, үр дүнг тооцох, тайлагнах үйл явц бүрдэж шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг болсон.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Ховд аймгийн Засаг даргын тамгын газраас 2011 онд нийт 2.35 тэрбум төгрөгийг суулгац нийлүүлэх, хамгаалалтын хашаа барих зэрэг ажилд зарцуулсан.

Энэ жишгээр 2011 онд 12 аймаг дэд хөтөлбөрөө боловсруулан АИТХ-аар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн ба жил бүр гарсан үр дүнг Цөлжилттэй тэмцэх үндэсний хороонд тайлагнан ажиллаж байна.

Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөрийн бүртгэл



- дэд хөтөлбөр батлагдан хэрэгжиж буй 12 аймаг
- дэд хөтөлбөр АИТХ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж буй аймгууд
- дэд хөтөлбөргүй аймгууд

Цөлжилт, газрын доройтолын үнэлгээ, мониторинг, зураглал

2011 оноос БОАЖЯ (одоогийн Байгаль орчин, ногоон хөгжлийн яам)-ны санаачлагаар “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хууль”-ийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

Монгол Улсын Их хурлаас 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр энэ хуулийг баталсан нь хуурайшилт эрчимтэй явагдаж байгаа өнөө үед цөлжилтийн эсрэг оновчтой бодлого, үйл ажиллагаа явуулах таатай эрх зүйн орчныг бий болгож байна.

Хуулийн хэрэгжилтийг эхнээс нь зөв зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олон нийтэд зориулан энэхүү хууль тогтоомжийн хялбаршуулсан лавлахыг бэлтгэн хэвлүүлж, зарим хэсгийг хошин зураг хэлбэрээр дүрслэн үзүүлэв.



“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хууль”-ийн хялбаршуулсан лавлахын зурагнуудаас

зургийг С.Цогтбаяр

ХӨРСНИЙ ДОРЙТОЛ БОЛОН ЦӨЛЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЗЭРЭГЛЭЛ



Төслийн дэмжлэгтэйгээр БОНХЯ-ны харьяа Байгаль орчны мэдээллийн төв ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнтэй хамтран “Монгол орны цөлжилт, газрын доройтлын төлөв байдал, цаашдын хандлагыг газрын

зурагт буулгах, мэдээллийн сан үүсгэх” ажлыг 2011 оноос хэрэгжүүлж цөлжилт, газрын доройтлыг үнэлэх олон улсын аргачлалыг Монголын нөхцөлд тохируулан ашиглах байдлаар шинэ арга зүй боловсруулав.



Газрын бүрхэвчийн зураг шалгах үеэр



Үндэсний түвшинд хийгдсэн энэхүү зурагт тулгуурлан илүү нарийвчилсан, тухайлбал нэг сум, багийн түвшний цөлжилт, газрын доройтлын учир шалтгаан, үр дагаварыг харуулсан зураг хийх боломжтой.

БОНХЯ-аас Монгол орны цөлжилт, газрын доройтлын төлөв байдал, цаашдын хандлагыг үндэсний хэмжээнд газрын зурагт буулгах ажлыг 10 жил тутамд нэг удаа хийж байх шийдвэр гарсан бөгөөд үүний дагуу дараагийн зурагт 2010-2020 оны цөлжилтийн төлөв байдал, цаашдын хандлага дүрслэгдэнэ.



Цөлжилт, газрын доройтлыг зураглах ерөнхий загвар (эх сурвалж: Бернийн их сургуулийн Хөгжил ба байгаль орчин төв)



Цөлжилтийн зураглал хийхэд ашиглагдах сэдэвчилсэн зургуудыг танилцуулах үеэр (зургийг Ханспитер Линигер)



Цөлжилтийн мэдээллийн сан

Хүчингэгч: [input type="text"]

Тайлбар: [input type="text"]

Хүчингэгчийн нэр: [input type="text"]

Хүчингэгчийн үйлдвэр: [input type="text"]

Хүчингэгчийн байршил: [input type="text"]


Хүчингэгчийн төрөл: [input type="text"]

Хүчингэгчийн үйлдвэр: [input type="text"]

Хүчингэгчийн байршил: [input type="text"]

Хүчингэгчийн төрөл: [input type="text"]

| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
|------------------|----------------------|----------------------|--------------------|----------------------|----------------------|--------------------|
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |
| Хүчингэгчийн нэр | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл | Хүчингэгчийн үйлдвэр | Хүчингэгчийн байршил | Хүчингэгчийн төрөл |



Үүний хамт “Цөлжилт, газрын доройтлын мэдээллийн сан” (www.eic.mn/DLDbase) олон нийтэд нээлттэй болов.

Энэхүү мэдээллийн сангаас иргэд цөлжилт, газрын доройтлын талаарх бүхий л мэдээллийг авах, судалгаа шинжилгээний хураангуй тайлантай танилцах боломжтой.

Төслийн дэмжлэгтэйгээр Цаг уур, орчны шинжилгээний газраас ахлан Монгол оронд цөлжилтийн үнэлгээ, хяналт шинжилгээ хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын оролцоотойгоор бэлчээрийн ургамал, хөрсний чанарын үзүүлэлтийг тодорхойлох “Цөлжилтийн хяналт шинжилгээний заавар”-ыг боловсруулж, БОАЖЯ (одоогийн Байгаль орчин, ногоон хөгжлийн яам)-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн сайдын 2011 оны А-144 тушаалаар батлав.





Инженер, техникийн ажилтнууд бүсчилсэн сургалтын үеэр



Цаг уур, орчны шинжилгээний газрын (ЦҮОШГ) төв, орон нутгийн бүх салбаруудын инженер, техникийн ажилтануудад энэхүү зааварын дагуу бэлчээрийн ургамал, хөрсний чанарын үзүүлэлтийг тодорхойлох мэдлэг, дадал эзэмшүүлэх бүсчилсэн сургалтыг мөн төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулав.

Одоо ЦҮОШГ-ын улсын сүлжээний 1500 гаруй байнгийн ажиглалтын цэгт ургамалын хэмжилтийг, хөрсний чанарын анхан шатны үзүүлэлтүүдийг 130 цэгт тодорхойлж байна.



Хөрсний дээж авч байгаа нь



ЦҮОШГ-ын инженер, техникчид

Дээрх ажлыг угтан 2011 онд төслийн санхүүжилтээр ЦУОШГ-ын нийт 11 лабораторийг хөрсний судалгаа шинжилгээний багаж төхөөрөмжөөр хангаж бүрэн тоногдосон.

Үүнийг Монгол оронд цөлжилтийн мониторингийн сүлжээ байгуулахад ШХА-аас оруулж буй чухал хувь нэмэр гэж БОНХЯ-ны зүгээс онцлон тэмдэглэж байгаа юм.

Эдгээр арга зүй, багаж, тоног төхөөрөмжийн тусламжтай цуглуулсан хөрс, ургамлын мониторингийн мэдээнүүд 2020 оны цөлжилт, газрын доройтлын зурагт тодорхой нэг бүтээгдэхүүн болон тусгагдах болно.



Лабораторийн тоног төхөөрөмжүүд




Хөрсний дээжид шинжилгээ хийж байгаа нь


2009–2012 онд зохион байгуулсан “Цөлжилт миний нүдээр” гэрэл зургийн уралдаанд ирсэн бүтээлүүдээс



1-р байр
“Дахиад л шуурга”
Т. Түвшин



2-р байр
“Ганцхан өнгө”
Э. Харцага



Тусгай байр
“Ус холдож, зам уртассаар”
Ү. Одбаяр



Ховд аймгийн усны менежментийг сайжруулах

Усны алдагдалыг бууруулж, үр ашигтай ашиглалтыг хэвшүүлэх

Монгол оронд усны нөөцийн хомсдол улам бүр хурцдаж тариаланчдын дунд усны талаархи маргаан гарах, усны хүрэлцээгүйгээс ургац буурах нь түгээмэл шинжтэй.

1991 онд Ховд аймгийн Буянт голын сав газарт улсын төсвийн 6 сая гаруй төгрөгийн өртөгтэй байгуулсан усалтын системийн Ховд, Буянт сумуудын нутаг руу ус хуваарилах “Жанжин боолт” хэмээх байгууламж баригдсан юм.


Монгол улсын өмч хувьчилалын эхэн үед ХАА-н нэгдлүүдийн бүх өмч хөрөнгийг гишүүд, ажиллагсадад нь хувьчилж тараасан боловч 500 га-аас том талбайтай усалтын системүүдийг орон нутгийн өмчийн мэдэлд үлдээхдээ түүнийг харж хамгаалах байгууллага хүмүүсийн орон тоо, цалингийн асуудлыг

шийдэлгүй орхигдуулснаас эзэнгүйдэж газар доорхи төмөр хоолойнуудыг хаягдал төмөрт нийлүүлснээр уг систем ажиллах боломжгүй болсон бөгөөд тариаланчид Буянт голоос гараар шуудуу татаж усалгаа хийж байсан бөгөөд 2006 онд улсын төсвийн хөрөнгөөр Жанжин боолтыг сэргээн засварлаж ашиглалтад оруулсан ч хоёр сумын тариаланчид усны хуваарилалтын асуудлаар маргалдан уг боолтыг эвдсэн байна.

Үүнээс хойш тариаланчид усны асуудлаар байнга маргалдаж хэрүүл зодоонд хүрдэг, гандуу жил, ялангуяа 6-7 дугаар саруудад усны хомсдолтой үед голын эхэнд байгаа тариаланчид ихэнх усыг нь авч голын адагт байгаа тариаланчид усны хомсдолд ордог.



Хуучны Жанжин боолтын толгойн барилга



Усны төлөөх ногоочдын зөрчилдөөн

Дээрхи нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр төслийн зүгээс шинэ услалтын систем барих ажлын эхний судалгааг хийлгэж, улмаар 2009-2011 онд ХХААХҮЯ (одоогийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам)-тай хамтран Ховд аймгийн Буянт голын сав газар нийт 2'400 га газрын хүчин чадал бүхий услалтын системийг барих ажлын эхний ээлжийг буюу 395 га-гийн толгойн барилга, үндсэн болон салбар сувагуудыг барьж дуусгасан.



Дараагийн ээлжийн 309 га-гийн барилгын ажлыг дуусгасан бөгөөд 2013 онд 3 дахь ээлжийн 367 га-г барьж эхлэхээр ҮХААЯ-тай тохироод байна. 2016 он гэхэд нийт 2400 га услалтын системийг барьж дуусгахаар ажиллаж байна.





395 га-гийн усалгааны салбар сүвгүүд
(Буянт голын сав газар, Ховд аймаг)



395 га-гийн усалгааны үндсэн суваг

Голын дагуух газар хуваарилалт ямар нэгэн бүртгэл, зохион байгуулалтгүй байсан тул салбар суваг буюу тухайн ногоочны талбайд хүрэх сувагуудыг тавих ажил ихээхэн хүндрэлтэй байсан.

Иймд Ховд аймгийн Газрын албатай хамтран газар эзэмшил, олголтын мэдээллийн санг бүрдүүлж, шинээр баригдсан услалтын системийн тариалангийн газрын дахин хуваарилалт, гэрчилгээжүүлэлтийг хийж газар ашиглалтыг хоёр дахин нэмэгдүүлээд байна.

Уг ажлын зарчим нь ногоочин өрх бүрт 3 га газраас илүүгүй хэмжээний газар эзэмшүүлэх явдал бөгөөд өнөөгийн байдлаар нийт гурван Ус ашиглагчдын бүлгийн 108 өрх айл 395-га гийн услалтын системээс усаа авч ашиглаж байна.

Газар хуваарилалт 2008 оны байдлаар



Газар дахин хуваарилалт 2012 оны байдлаар (өрх бүрт 3 га газраар)



Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын 2000 га-гийн услалтын системийн толгойн барилгыг сэргээн засварлаж 2012 онд 200 га талбайд тарилалт хийсэн нь өнгөрсөн жилээс даруй 129 га-аар нэмэгдсэн.

Тус сумд 5 аж ахуйн нэгж, 6 өрх нэгдэн Ус ашиглагчдын бүлэг байгуулан усаа хуваарьтайгаар ашиглаж байна.

*Эрдэнэбүрэн сумын
услалтын системийг
сэргээн засварлах
ажлын үеэр*



Ногоочдын сургалтын үеэр



Зөвхөн дэд бүтцийн асуудлыг шийдэхээс гадна ногоочдыг зохион байгуулалтанд оруулах, шаардлагатай сургалтанд хамруулан чадавхижуулах зэрэг ажлууд юу юунаас чухал.

Ийнхүү голын дагуух ногоочид Ус ашиглагчдын бүлгүүдэд сайн дурын үндсэн дээр нэгдэн орж, усаа нэгдсэн усалгааны суваг, системээс тодорхой хуваарийн дагуу авч, орчин үеийн арга, технологийг хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг сайжруулах, ургацаа арвижуулах, улмаар ашиг орлогоо нэмэгдүүлэх чин хүслийг нь төслийн зүгээс дэмжсэн юм.



Ногоочид усалгааны сувгаа тодорхойлж зурагласан байдал

Ус ашиглагчдын бүлгийн гишүүдийн анхдугаар хуралдаан



Ус ашиглагчдын бүлгийн гишүүдийн анхдугаар хуралдаан



Ус ашиглагчдын бүлгийн анхдугаар уулзалтаар ногоочид усалгааны хуваариа ярилцаж байгаа нь



Ийнхүү бүлгүүд усны хомсдолыг бууруулах, ургацаа нэмэгдүүлэх, тариалангийн талбайгаа хөрсний элэгдэлээс хамгаалах зорилгоор “Буянт голын усыг газар тариаланд ашиглагчдын холбоо”-г (УАХ) байгуулж, хууль эрх зүйн хувьд баталгаатай болон ажиллаж байна.

2012 оны байдлаар Ховд аймгийн Буянт голын сав газарт тариалан эрхлэж буй нийт ногоочин өрхүүдийн 76% хувь нь буюу 759 айл 38 Ус ашиглагчдын бүлгүүдэд нэгдэж хөрсний үр жил шимээ сайжруулах, усны нөөцийг зохистой ашиглах, хураасан ногоогоо зах зээлд борлуулах зэрэг ажлуудыг хамтын хүчээр шийдвэрлэж байна.

2013 онд Холбоо нь өөрийн үйл ажиллагаагаа явуулах 200 м² гаруй талбай бүхий ажлын байртай болж, цаашид тогтвортой ажиллах боломжтой болж байгаа юм. Уг байранд ногоочдын түүхий эдийг боловсруулах жижиг цех ажилуулж, бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны цэгийг мөн нээн ажиллуулах юм.




Шинээр байгуулагдсан УАБ-ийн гишүүд



УАХ-ны ажлын байр баригдаж байгаа нь

Тариаланчид Ус ашиглагчдын бүлэг (УАБ)-т нэгдэж, зохион байгуулалтад орсон нь



Цөлжилттэй тэмцэх талаар төслөөс хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагаа

2400 га газрыг хамрах хүчин чадал бүхий усралтын систем баригдахаас

395 га ийн үндсэн болон салбар сувгууд тавигдсан.

309 га газрын усралтын систем 2012 онд ашиглалтад орно

Усны тэгш бөгөөд үр ашигтай хуваарилалт бий болсон

Шавран зуухыг цахилгаан тогоогоор солих

Ховд аймгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн



1161 га газрын ургамлан бүрхэвчийг хамгаалах боломжтой

Бүлгүүд 2010 оноос эхлэн жил бүр ҮХААЯ-аас зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд оролцож шагналын хур буулгана.



2011 онд “Хөх цөцгийт”, 2012 онд “Буянтн нахиа” бүлгүүд тус бүр “Шилдэг ногоочин” шагнал гардсан нь цаашид хүчээ хоршин хийж бүтээх урам зоригийг өгсөн явдал болсон юм.



Ногоочдын ургацын баярын өдөр



Ховд аймгийн “Ногоон төгөл”

Ховд аймгийн нисэх буудлаас аймгийн төв хүртлэх зам дагуу нийт 3,5 га талбайг хамарсан “Ногоон төгөл”-ийг орон нутгийн иргэд, тариаланчдын хамтаар бий болгосон.

Анх энэ хэсэг газарт хайрга, чулуу ихтэй, ургамал ногоо ургадаггүй, салхи ихтэй байсан бол өнөөдөр энэ талбайд чацаргана, интоор, алим, бөөрөлзгөнө, сухай, агч мөн 20 гаруй нэр төрлийн жимс жимсгэнэ, гоёл чимэглэлийн модлог, бутлаг ургамал зэрэг ургана.

2008 он



2009 он



2010 он



2011 он



2012 он



Ногооны хүлэмж 2009 онд



Ногооны хүлэмж 2012 онд



Дуслын усалгаа

Жилдээ 10 гаруй сая төгрөгийн ашигтай байж жилээс жилд ургац, орлого нь нэмэгдэнэ гэсэн тооцоолол гаргасан ба талбайд ус ашиглагчдын бүлгийн гишүүдэд үржүүлэг хийх сургалтыг өгч, газар дээр нь туршилт хийж, мэдлэг олгоно.

Хучлагатай тариалалтын технологи

Усны хэрэглээг 30%-иар бууруулж, ургацын хэмжээг 24%-иар нэмэгдүүлэх боломжтой нийлэг хучлагатай тариалалтыг Ховдын Буянт голын сав газарт тариалан эрхэлж буй 381 ногоочин өрхүүдийн 87 га талбайд байцаа болон улаан лооль дээр нэвтрүүлсэн.

Байцаан дээр хийсэн хучлагатай технологийн туршилт



Улаан лооль дээр хийсэн хучлагатай технологийн туршилт



Ойн зурвас

Цөлжилтийн сааруулах төслийн үйл ажиллагааны хүрээнд Ховд аймагт тариалангийн талбайг салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах ажил жилээс жилд нэмэгдэж 2012 оны байдлаар нийт 110 мянга гаруй мод тариалагдаж нийт 550 орчим га тариалангийн талбайг салхиний элэгдэлээс хамгаалах боломжийг бүрдүүлээд байна.



Ойн зурвасны
ТЕХНОЛОГИ
SHELTERBELT

УАБ-үүд шинэ технологи туршиж, хэрэгжүүлсэн нь

Ус хэмнэх:



Үр дүн:

Ус 30% хэмнэж
 Ургац 24% нэмэгдэж
 Орлого 29%-иар өссөн

Хөрс хамгаалах:



Үр дүн:

1652 га газрыг хөрсний элэгдлээс хамгаалах боломжтой

Ойн зурваст тариалсан модны тооллогын үеэр



Ээлжлэн тариалалт

Ховд аймгийн Буянт голын дагуу газар тариалан эрхлэгчид жил бүр талбайгаа бууцаар борддог боловч бууц нь бага хэмжээтэй мөн сайн ялзраагүйгээс хортон шавьж гарч ургац алдах явдал багагүй гардаг.

Үүнээс шалтгаалан хөрсний ялзмагийн хэмжээ багасч, улмаар хөрсний бүтцэд сөрөг нөлөө үзүүлдэг. Ээлжлэн тариалалтын сэлгээнд буурцагт ургамлыг тариалсанаар аливаа нэгэн тарималын ургацыг хувиар нэмэгдүүлэх боломжтой.



Цахилгаан зуух төсөл

Ховд аймгийн нийтийн үйлчилгээний газар, сургууль, цэцэрлэгүүд хоол, цай бэлтгэхдээ заг, хайлаас, харгана, бут түлж говийн эмзэг хөрсийг сахинд хийсэх, элсний нүүдэлд дарагдах нөхцлийг бүрдүүлдэг.

Төслөөс сургуулийн дотуур байр, эмнэлэг, цэцэрлэгийн 43 байгууллагад хоолны цахилгаан зуух, ус буцалгагч нийлүүлж бэлчээрийг элэгдэлээс хамгаалах боломж бүрдүүлсэн.

Өөрсдөө тарьсан ногооны дээжээ амсаж байна, Ховд аймгийн, II-р сургуулийн эко клубын сурагчид





Шар буурцаг тариалах

Шар буурцаг нь ургалтын хугацаандаа үндэснийхээ булцууны бактерийн тусламжтайгаар хөрсөнд азот хуримтлуулж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхээс гадна сүүлийн жилүүдэд хоол хүнсэнд өргөн хэрэглэгдэх болсон.

Ногоочид төмс, хүнсний ногоог дагнан тариалдагаас шалтгаалж борлуулах зах зээл муутай болж намар ургацаа хямдхан өгч орлого нь буурдаг.

Иймээс төмс, хүнсний ногоог дагнан тариалдаг байдлыг өөрчилж таримлын нэр төрлийг нэмэгдүүлж шар буурцаг тариалан орлогоо нэмэгдүүлэх боломж нэмэгдэж байгаа юм. Нэг кг шар буурцаг ойролцоогоор 5000 төгрөгийн үнэтэй зах зээлд борлогддог.




Намрын цэнэг усалгаа

Хаврын тариалалтын үед усны хэрэглээ улам ихэсдэг тул намрын цэнэг усалгаа хийсэнээр усны ачаалалын үед нэг удаагийн усалгааг хэмнэснээрээ усны маргааныг зөв шийдэх боломж бүрдэж байгаа юм.


Үүнээс гадна намар ургац хураасны дараа ногоочид талбайдаа намрын цэнэг усалгаа хийж хөрсийг хавар, намрын шороон шуурганаас хамгаалаж эрт тариалалт хийх боломж бүрдэж байгаа юм. Ингэснээр эрт ургац авч ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой.




2009–2012 онд зохион байгуулсан “Цөлжилт миний нүдээр” гэрэл зургийн уралдаанд ирсэн бүтээлүүдээс



1-р байр
“Дорноговьд”
Н. Дуйнхар



2-р байр
“Төвийн цөлжилт”
Г. Эрдэнэтуяа



3-р байр
“Цөлжилт”
Б. Амарзаяа

Эко-сургууль хөтөлбөр ба Мэдээлэл сурталчилгаа

Миний сургууль-эко сургууль

Байгаль эхээ зүрхэндээ тээсэн бяцхан хүүхдийн урамыг нь тэтгэж, байгальд ээлтэй хүн болгон төлөвшүүлэх зорилгоор эко-сургуулийн үзэл баримтлалыг 2007 оноос хойш нийт 11 аймгийн 77 ерөнхий боловсролын сургуулийн 61600 сурагч, 3500 багш, сурган хүмүүжүүлэгч нарыг хамруулан хэрэгжүүлж байна.

Эко сургууль санаачлага нь анх 1992 оны Рио-де-Жанейро хотноо болсон НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн зөвлөлгөөнөөс гарсан санаачлага бөгөөд “Байгаль орчны боловсролын сан” олон улсын ТББ нь 7 алхам бүхий “Эко-сургууль” үзэл баримтлалыг Европын Холбооны тусламжтайгаар анхлан боловсруулсан юм.

Хүүхэд, эцэг эх, багш нарын байгаль орчиноо таньж мэдэх, хамгаалах, нөхөн сэргээх мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий энэхүү хөтөлбөрийг бусдад үлгэр дууриалал болохуйц сүлжээ болгон өргөжүүлж, улмаар байгаль орчны боловсрол олгох төрийн бодлогын хэрэгжилтийг хангах чадвар, чадамж бүхий эко-сургуулиудын хөдөлгөөн болгон өргөжүүлэх эхтэйн зорилго тавин ажиллаж байна.



“1000 цэцэгс”-ийн баярт зориулан тариалсан цэцэгс



Хаягдал хайрцагаар бүтээсэн хогны сав



Хөвд аймгийн Эко сургуулийн сурагчид



Хаягдал даавуугаар оёсон цүнх

Сурагчдын
бүтээлийн
үзэсгэлэнгийн үеэрХийсэн ажлаа
баримтжуулсан
зурагт самбарСурагчид хүлэмжинд нарийн
ногоо тариалдаг


Булгийн эхийг хамгаалсан нь



Сургуулийнхаа орчинг тохижуулав



Эко сургуулийн сурагчдын гар зургаас



Эко-сургуулиудын чуулга уулзалт Ховд аймагт



Байгальд ээлтэй иргэн төлөвшүүлэх санал санаачлагаа санхүүгийн хувь хараат бус, шийдвэр гаргах түвшинд бие даан хэрэгжүүлэх нь эко-сургуулиудын хувьд томоохон хүчин зүйл. Чухам энэ л тухай туршлага, мэдлэг мэдээллээ солилцох гэж 10 аймгийн эко-сургуулийн 70 гаруй оролцогсад Ховд аймгийн төвд цугларан чуулсан.



Уулзалтын үр дүнд одоо хэрэгжиж буй эко-сургууль хөтөлбөрийн үзэл баримтлалыг хөдөлгөөн болгон өргөжүүлж, улмаар үйл ажиллагаагаа илүү урт хугацаанд, тогтвортой хэрэгжүүлж, бодит үр дүн гаргах нь зүйтэй байна хэмээн оролцогсад санал нэгдсэн юм. Түүнчлэн хөдөлгөөн өрнүүлсэнээр сургуулиудын өөрийн удирдлага бэхжиж, цаашид төсөл хөтөлбөрөөс үл хамааран хэрэгжиж боломж бүрдэнэ хэмээн үзсэн.

Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих

2010 онд Монгол улсын ерөнхий боловсролын сургалт 12 жилийн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан сургалтын хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын үзэл баримтлалыг тусгах завшаан тохиосон юм.

Дээрхи үзэл баримтлалыг сургалтын хөтөлбөрт тусгах үүрэг хүлээсэн ТХБ-ын багт техник, санхүүгийн дэмжлэг үзүүлснээр уг үзэл баримтлал тусгагдсан 4 болон 9 дүгээр ангийн сургалтын хөтөлбөрүүд шинээр батлагдсан юм. Ингэснээр өдгөө нийт ерөнхий боловсролын сургалтын бүх ангийн хөтөлбөрт ТХБ үзэл санаа тусгагдсан.

ТХБ нь UNESCO-гийн санаачлага бөгөөд Монгол улс гишүүн орныхоо хувьд тодорхой үүрэг хариуцлага хүлээх үүрэгтэй. ТХБ-ын агуулга нь оюутан сурагчдыг байгаль хамгаалал, нийгмийн асуудалд идэвхи, санаачлагатай оролцуулж улмаар залуу үеийнхэний хандлагад эерэг өөрчлөлт оруулах зорилготой.



Мэдээлэл сурталчилгаа

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй ажиллах байдал

Ховд аймгийн Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран иргэдэд цөлжилтийн талаархи мэдээлэл, сурвалжлага түгээх ажлыг хэрэгжүүлж байна. Түүнчлэн тус аймагт цөлжилтийн эсрэг хэрэгжүүлж буй шилдэг, сайн туршлагуудыг баримтат кино болгон баримтжуулж, орон нутаг төдийгүй, төвийн мэдээллийн хэрэгсэлээр түгээн дэлрэгүүлж байна.

МҮОНРТ-ийн “Ногоон хөгжил” болон UBS ТВ-ийн “Ногоон ирээдүй” зэрэг иргэдэд танил болоод байгаа байгаль орчны нэвтрүүлгээр цөлжилтийн эсрэг төрөөс баримтлаж буй бодлого, сайн туршлага, гарсан үр дүнг нийтэд хүргэх ажлыг шат дараалалтайгаар зохион байгуулдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр жил бүрийн 06 дугаар сарын 17-ны өдөр тохиодог Дэлхий нийтээр цөлжилттэй тэмцэх өдрөөр Цөлжилт миний нүдээр гэрэл зургийн үзэсгэлэн/уралдааныг зохион багуулдаг уламжлал тогтоосон.





Энэхүү уралдаанаар бид гэрэл зургийн агшинаар дамжуулан Монгол орны цөлжилт, хуурайшилтийг дүрслэн харуулахын сацуу түүний эсрэг хүн, байгалийн тэмцлийг өгүүлж, цөлжилт бидний хувь тавилан биш гэх санааг нийтэд хүргэхийг зорино.

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн чадварлаг сэтгүүлчид Сэтгүүлч байгаль орчны төлөө буланг өдөр тутмын сонинд ажиллуулахад дэмжлэг үзүүлэн ажилласанаар иргэд дан ганц цөлжилтийн талаар бус мөн байгаль орчны бусад асуудлаар тууштай дагнан бичих боломжийг бүрдүүлж байна.



Сэтгүүлчдийн нийтлэлийг www.ecosetguulch.mn цахим хуудсанд байрлуулсан бөгөөд цахим хуудсыг нэмж баяжуулах боломжтой юм.



Сэтгүүлч байгаль орчны төлөө

“Сэтгүүлч байгаль орчны төлөө” аяны шилдэг сэтгүүлчид (Өнөөдөр сонины сэтгүүлч Д.Оюу-Эрдэнэ, Зууны мэдээ сонины сэтгүүлч Х.Хулан, Үндэсний мэдээ сонины сэтгүүлч Ж.Тагтаа, Өдрийн шуудан сонины сэтгүүлч Л.Оюунгэрэл)



Цөлжилт болон байгаль орчны бусад асуудлуудын тухай мэдлэгийг урлагаар дамжуулан дээшлүүлэх зорилгоор “Шар тэнгисийн тарчлаан” дуулалт жүжгийг бүтээж, Улсын драмын эрдмийн театрын тайзнаа тоглоход дэмжлэг үзүүлсэн.

Өвөрмөц арга барилаар бүтээгдсэн, харьцангуй цогц шийдэлтэй энэ бүтээл хүмүүс хэтэрхий хожимдож ухархасаа өмнө байгаль орчинд хандах хандлагаа өөрчлөхийг уриалснаараа тэдний ойлголт мэдлэгийг дээшлүүлэх хүчирхэг хэрэгсэл болж чадсан юм.



Сараана охин чухам яагаад байгаль дэлхий ингэж их хилэгнэн уурлаж, ширүүн салхи дэгдүүлж, нүүр нүдгүй цохих болсон шалтгааныг мэргэн эмгэнээс олж мэдэхээр шороон шуурганы ширхэг бүрд нүдүүлэн алхлана... Ийнхүү оньсого болон өрнөх “Цэцгийн амь” хүүхэлдэйн жүжгийг Ховд аймгийн бяцхан иргэд, эцэг эхчүүд шимтэн сонирхлоо.

Жүжигт байгаль эх хүний балагт үйлдлийг тэсч тэвчилгүй, хүн, амьтан адгуусыг ч үл хайрлан хилэгнэж байгааг өгүүлнэ. Харин энэ учрыг тайлахын тулд өөдөсхөн чинээ Сараана охин алс холын шидэт эмгэн дээр очин гуйж ямар шалтгаантай байсныг олж мэдсэний үр дүнд зон олон нь ч ухаарч, байгаль эх сая нэг тайтгарна.

Жүжгийг Монголын зохиолчдын эвлэлийн шагналт, хүүхдийн зохиолч Д.Батжаргалын зохиолоос сэдэвлэн бүтээсэн ба жүжгийн тавилт, ерөнхий найруулгыг Эрдэнэт хотын хүүхэлдэйн театрын найруулагч, зураачид гүйцэтгэж, Ховд аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчид тайзнаа амилуулсан юм.

Ховд аймгийн Хүүхэд, залуучуудын соёл, амралтын хүрээлэн

Ховд аймгийн Хүүхэд, залуучуудын соёл амралтын хүрээлэнг бүтээн байгуулахад хувь нэмрээ оруулж нийт 1.5 га газрыг бүрэн тохижуулах ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Энэ дэмжлэгийн хүрээнд өнгө үзэмж бүхий сүүдрэвч барих, сандал хийх, элсэн тойрог хийх, бага насны хүүхэд тоглож наадах зөөлөвчтэй шал суулгах, гоёлын мод, бут тариалах зэрэг ажлууд орсон ба энэ бүх ажилд Ховдын эко-сургуулиудын цөм болох Ногоон Ховд ТББ-аар удирдуулсан эко-сургуулийн хүүхдүүдийн оролцоо чамгүй их байсныг онцлож байна.

Хүүхдүүд тухайн тохижуулсан буландаа өөрийн сургуулийн таних тэмдэг бүхий самбар байрлуулж, улмаар зуны цагт өөрсдийн дуу хоолой, хүсэл сонирхлоо илэрхийлэх бяцхан арга хэмжээ, цугларалт зэргийг зохион байгуулах боломжтой болж байгаа юм.





Мэдлэгийн менежмент


ШХА-ийн зүгээс Монгол Улсын шинжлэх ухааны академийн Гео-экологийн хүрээлэн (ГЭХ)-ийн харъяа Цөлжилтийн судалгааны төвд 2008 оноос хойш санхүү, техникийн дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний дунд тус төвийн судлаачид гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж улмаар Монгол улс “Дэлхийн хөрс, ус хамгаалах арга барил, технологи” бүртгэлийн WOCAT сүлжээ”-ний (www.wocat.org) гишүүн орон болов.

Ховд аймгийн хэмжээнд цөлжилт, газрын доройтолын эсрэг хэрэгжүүлж болох арга, технологийг ГЭХ-ийн эрдэмтэд судлан тодорхойлж зурган хэлбэрт оруулан шийдвэр гаргач нарт хүргэсэнээр үүний дагуу тодорхой ажлуудыг төлөвлөх боломжтой болж байна.

Энэхүү ажлын хүрээнд эхний ээлжинд Ховд аймгийн Чандмань, Буянт сумдын цөлжилт, газрын доройтолын үнэлгээ хийж, зураглал боловсруулсныг сумдын менежментийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлэхээр тохирсон.



Ховд аймгийн Чандмань сумын газрын доройтол цөлжилтийн зураглалыг танилцуулж байна.



Цөлжилтийн судалгааны төвд цөлжилтийг сааруулах мэдлэг, технологи, арга барил, зураг, хэрэгслүүдийг бүртгэх, нэгтгэх “Монгол орны хөрс, ус хамгаалах арга барил, технологийн сан” (www.moncat.mn) байгуулагдаж, олон нийтийг энэ талаарх мэдээ мэдээллээр хангах мэдээллийн төвийг ГЭХ-ийн номын санд түшиглэн байгуулсан.



Бортгонд заагийн үр тариалах технологи



Шавраар хашаа барих технологийг нэвтрүүлсэн “Төгс ирээдүй” УАБ-ийн гишүүд

Булган аймгийн Рашаант сумын нутаг дахь Элсэн тасархай дахь “Цөлжилтийн хээрийн суурин судалгааны төв”

Цөлжилтөд нөлөөлж буй гол хүчин зүйлийг тодорхойлох, цөлжилтийг сааруулах оновчтой арга замыг тогтоох, хөрс, ус хамгаалах болон газрын доройтлыг бууруулах дэвшилтэт технологийг турших, үр дүнд хүрсэн аргуудыг олон нийтэд таниулж, сурталчлах зэрэг ажлыг Гео-экологийн хүрээлэнгийн санаачлагаар Булган аймгийн Рашаант сумын “Элсэн тасархай” хэмээх газарт байгуулагдсан “Цөлжилтийн туршилт, судалгааны төв”-д хэрэгжүүлж байна.

Судалгааны төвтэй болсоноор хээрийн бүсэд урт хугацаанд цөлжилтийн нарийвчилсан судалгаа явуулж, байгалийн хувьсал өөрчлөлтийг судлах, цөлжилтийг сааруулах арга туршлага, технологиудыг туршин судалгаа явуулсаны үр дүнд шууд нэвтрүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх боломжтой болж байгаа юм.



Гэрэл зургийг Б.Инжинааш,
2012 оны “Цөлжилт миний нүдээр”
гэрэл зургийн уралдааны тэргүүн
байрын шагналт



Швейцарийн хөгжлийн агентлагийн
Цөлжилтийг сааруулах төсөл

МОНГОЛД